

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийн хөрөнгийг хуулинд заасан хэмжээгээр төлөвлөж батлаагүйгээс аймгийн ГХУСАЗСЗ зарим чиг үүргээ хэрэгжүүлж чадаагүй байна.



"Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудит

2017 он

Уг тайланг WWW.AUDIT.MN сайтаас үзнэ үү.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70463783 , 70463612 дугаарын утсаар харилцана уу

ХАЯГ: Завхан аймгийн
Аудитын газар
Улиастай сум, Жинст багийн
Нутгийн захиргааны ордон
309, 310 тоот өрөө

Гүйцэтгэсэн :

Аудитор
Г.Заяа
Н.Батбилэг
Б.Жалбаа

Хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор
Л.Уламбаяр Ахлах
аудитор Д.Оюунжаргал

2017.10.23

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх	5-11
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байгаа эсэх	12-14
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байгаа эсэх	15-18
Дүгнэлт	19-20
Зөвлөмж	21-22

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

- ИТХ - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- ЗДТГ - Засаг даргын тамгын газар
- ОБХ - Онцгой байдлын хэлтэс
- ИТХХ - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаан
- МХГ - Мэргэжлийн хяналтын газар
- ОНХС - Орон нутгийн хөгжлийн сан
- ГХУСАЗСЗ - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийв.

Аудитын зорилт

Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийсэн. Үүнд:

- Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдсан эсэх

Хамарсан хүрээ

Аудитаар 2015-2017 оны аймаг, сумдын ГХУСАЗСЗ, аймгийн Прокурорын газар, аймгийн Цагдаагийн газраас хэрэгжүүлсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг хамруулан шалгалаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашигласнаас гадна аймгийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажилтан, аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, аймгийн Цагдаагийн газрын болон аймгийн Прокурорын газрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, байгууллагын санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Ерөнхий мэдээлэл:

Аймгийн ГХУСАЗСЗ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг 2015 онд 27.5 сая төгрөгийн, 2016 онд 27.5 сая төгрөгийн, 2017 онд 29.5 сая төгрөгийн төсөвтэйгээр батлуулсан байна.

Аймгийн Засаг даргын нөөц сангаас 2015 онд 11.0 сая төгрөгийн, 2016 онд 13.4 сая төгрөгийн, 2017 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 4.6 сая төгрөгийн санхүүжилтүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд нэмж хуваарилсан байна.

Аймгийн ГХУСАЗСЗ нь 2015 онд 7 чиглэлийн 47 арга хэмжээнд 44.9 сая төгрөгийг, 2016 онд 8 чиглэлийн 33 арга хэмжээнд 18.0 сая төгрөгийг, 2017 онд 4 чиглэлийн 28 арга хэмжээнд 91.5 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Бүлэг 1.1 Төсөв хөрөнгөний дутагдалтай байдал нь гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцлийг арилгах нийгэм эдийн засаг, эрх зүйн арга хэмжээний хэрэгжилтэнд нөлөөлж байна.

1.1.1 Ихэнх гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох чиг үүрэг хэрэгжиж байгаа ч иргэний өмч хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг орхигдсон байна.

2015 оны 06 дугаар сараас хойш аймгийн Цагдаагийн газар эрүү, хэв журмын нөхцөл байдлын мэдээг 7 хоног бүр, аймгийн Прокурорын газар гэмт хэргийн мэдээллийг хагас, бүтэн жилийн байдлаар нэгтгэн, эрүүгийн нөхцөл байдлын талаарх танилцуулгын хамт аймгийн ГХУСАЗСЗ –д тогтмол ирүүлжээ.

Аймгийн Цагдаагийн газрын статистик мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Гэмт хэргийн ангилал										
Он	Гэмт хэргийн тоо	Мал хулгайлах	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын тухай журмын эсрэг	Насанд хүрээгүй иргэдээс үйлдэгдсэн	Согтуугаар үйлдэгдсэн	Гэр бүлийн хүчирхийлэл	Иргэний өмч хулгайлах	Бусад	Нас барсан хүний тоо	Гэмтсэн хүний тоо
2014	312	42	23	30	65	9	74	69	13	107
2015	225	21	19	12	86	5	53	29	29	93
2016	259	16	15	23	104	17	80	4	17	90
2016 оны 1-9 сар	194	11	11	19	73	5	75		7	71
2017 оны 1-9 сар	168	7	14	9	44	3	48	43	29	67

Аймгийн прокурорын газрын эрүүгийн нөхцөл байдлын танилцуулгад 2015-2016 онд мал хулгайлах, гэр бүлийн хүчирхийлэл, архидан согтуурахтай тэмцэх чиглэлд, 2017 онд өмнөх онуудын 3 чиглэл дээр орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийг нэмж анхаарах талаар тусгажээ.

Аймгийн цагдаагийн газрын даргын 2016 оны А/46 тоот тушаалаар аймгийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг судалж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой, үр дүнтэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх криминологи судалгааны багийг байгуулсан байна.

Криминологи судалгааны баг нь 2016-2017 онуудад аймагт зонхилон үйлдэгддэг доорх гэмт хэргийн шалтгааныг тогтоосон боловч дүгнэлт, зөвлөмжөө аймгийн ГХУСАЗСЗ –д хүргүүлээгүй байна.

Үүнд:

- 1. Өмчлөх эрхийн эсрэг буюу хулгайн гэмт хэрэг нь:** аж ахуйн нэгж байгууллагын харуул, хамгаалалт болон камержуулалт нь шаардлага хангахгүй, иргэдийн сонор сэрэмжгүй, хайхрамжгүй байдал, гэр орноо олон хоног, сараар эзэнгүй орхидог, малчид малыг хариуллагагүй орхидог, бусдын өмчийг хулгайлах үйлдлүүдийг хохирлын хэмжээ хүрэхгүй гэсэн шалтгаанаар эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан нь дахин гэмт хэрэг үйлдэх сэдлийг бий болгож гэмт хэрэг гарахад нөлөөлж байна.
- 2. Хүний амьд явах эрхийн эсрэг буюу хүний амь, бие, эрүүл мэнд хохироох хэрэг нь:** Гэр, орон сууцанд архидан согтуурсаны улмаас иргэдийн хооронд зүй бус таарамжгүй харьцаа үүсэх, биесээ хүндэтгэдэггүй байдал, хууль эрхийн мэдлэг сул, хувь хүний ухамсар, ёс суртахууны доголдол, танхай байдал, амьдралын түвшин баталгаажих түвшингөөс доогуур, ажилгүйдэл, стресс ихтэй байдлаас хамааралтай.
- 3. Тээврийн хэрэгсэл, хөдөлгөөний аюулгүй байдлын ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг нь:** Орон нутгийн замд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, хурд хэтрүүлэх, бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодох, жолоочийн ур чадвар дутмаг зэрэгтэй холбоотой

Эдгээр гэмт хэргүүдийн ихэнхи хувийг согтуугаар үйлдэгдсэн бөгөөд 17-50 насны иргэд холбогдож байгаа нь дараах шалтгаантай байна.

- Бусад аймаг, хотоос иргэд олноор ирж хууль бусаар алт олборлох, хуучны эд зүйл худалдан авах зар сурталчилгаа явуулж, эд зүйлийн өндөр үнээр авч байгаа байдал
- Архи согтууруулах ундаа борлуулах цэг, салбарын тоо аймгийн хэмжээнд их байдаг.

Криминологи судалгааны багаас архи, согтууруулах ундаа борлуулагчдын тусгай зөвшөөрлийг олгохдоо хүн амын нягтралшилтай уялдуулах, гудамж талбайд камержуулалтын ажлыг хийх гэсэн зөвлөмжийг гаргажээ.

2015-2017 онд аймгийн ГХУСАЗСЗ нь:

- Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх
- Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
- Хорих ял эдлээд суллагдсан иргэнийг нийгэмшүүлэх гэсэн гэмт хэргүүдийн шалтгаан, нөхцлийг арилгах чиглэлээр ажлаа төлөвлөсөн боловч иргэний өмчийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийг төлөвлөгөөнд тусгаагүй байна

1.1.2 Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцлийг арилгах нийгэм эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж байгаа ч хэрэгжилт нь хангалтгүй байна.

Аймгийн ГХУСАЗСЗ нь Цагдаагийн газар, Шүүхийн тамгын газар, Прокурорын газар, Онцгой байдлын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Мэргэжлийн хяналтын газар зэрэг байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн 2015 онд 7 чиглэлийн 47 арга хэмжээнд 44.9 сая төгрөгийг, 2016 онд 8 чиглэлийн 33 арга хэмжээнд 18.0 сая төгрөгийг, 2017 онд 4 чиглэлийн 27 арга хэмжээнд 91.5 сая төгрөгийг зарцуулахаар тус тус төлөвлөсөн байна.

Гэтэл аймгийн ГХУСАЗСЗ нь 2015 онд 27.5 сая төгрөгийг төсөвлөн батлуулсан хэрнээ 44.9 сая төгрөг зарцуулахаар, Цагдаагийн газар, аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, Прокурорын газрууд тус тусдаа сумдад бүсчлэн сургалт зохион байгуулахаар санал ирүүлснийг зөвлөл хяналгүйгээр нэгдсэн төлөвлөгөөнд тусган оруулсан зэргээс дүгнэлт хийхэд тус оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт уялдаа холбоо хангалтгүй, тооцоо судалгаагүй байна гэж үзлээ.

2015 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгахад биелэлт нь 57.4 хувьтай, 6 чиглэлийн доорх 20 арга хэмжээ нь хэрэгжээгүй байна. Үүнд:

- Аймгийн ГХУСАЗСЗ –ийн хурлыг улирал бүр хийх, аймгийн Нэгдсэн эмнэлэг болон сумдын эрүүл мэндийн төвүүдэд архины хордлого тайлах эмчилгээ явуулдаг тусгай өрөөнүүдийг шинээр бий болгох, эрх зүйн орчныг бүрдүүлэх гэсэн 2 ажил
- Аймагт батлагдаж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсөв бага байдгаас шалтгаалан олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг сурган дадлагажуулах, урамшилт эргүүлүүд, сургууль цэцэрлэгийн орчим сайн дурын ажилтныг ажиллуулах гэсэн 3 ажил
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас ирүүлсэн саналын дагуу цагдан хорих байрыг цахилгаан үүсгүүр, фото аппаратаар хангах ажлын төлөвлөгдсөн боловч шаардлагатай санхүүжилтийн хэмжээг тооцоолоогүй, төсөв хөрөнгийн асуудлыг тусгаагүй
- Батлагдсан төсөвгүйгээр төлөвлөгдсөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх санаачлагатай ажилласан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах 2 ажил, сургалт сурталчилгааны 8 ажил
- Аймгийн ГХУСАЗСЗ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүйгээс аймгийн Цагдаагийн газарт 11.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосонтой уялдан сургалт, сурталчилгааны 2 ажил, хөдөлгөөнт эргүүлүүдийн автомашиныг камержуулах, эрүү хэв журмын нөхцөл байдлын криминологийн судалгааг гарган, үнэлгээ хийх зэрэг нийт 4 ажил

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг Аймгийн ГХУСАЗСЗ нь 2016 онд 29.5 сая төгрөгийн төсөвтэйгээр баталсан байхад 18.0 сая төгрөгийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд, 6,8 сая төгрөгийг аймгийн ГХУСАЗСЗ-ийн ажилтныг цалинд зарцуулна гэж төлөвлөөд, 4.7 сая төгрөгийг төлөвлөлгүй орхисон байна.

Энэ төлөвлөлтөөс харахад 2016 оны төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлэхэд батлагдсан санхүүжилт бүрэн хүрэхээр байгаа боловч аймгийн ГХУСАЗСЗ-ийн зориулалт бус зарцуулалтаас шалтгаалан 6 чиглэлийн 16 арга хэмжээ нь хэрэгжээгүй, биелэлт 51.5 хувьтай байна.

- Аймгийн ГХУСАЗСЗ –ийн хурлыг хагас, бүтэн жилээр хийх, сумдын салбар зөвлөлийн ажлын тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн, үнэлэлт өгөх, Татварын буцаан олголтыг Улиастай, Тосонцэнгэл сумдад шалгах гэсэн 3 ажил
- Боловсрол соёлын газар болон Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн хэлтэс хариуцан зохион байгуулах насанд хүрээгүй иргэдэд чиглэсэн 2 арга хэмжээ
- Аймгийн ГХУСАЗСЗ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтээс 12.0 сая төгрөгийг зориулалт бус зарцуулснаас шалтгаалан архинд донтой иргэдийг албадан эмчилгээнд хамруулах, сургалт сурталчилгааны ажлууд, ГХУСАЗСЗ–ын нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулах, Тосонцэнгэл, Их-Уул, Алдархаан, Сантмаргац, Идэр, Отгон сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах, сумдын салбар зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөн хийх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх санаачлагатай ажилласан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах, хяналт шалгалт хийх гэсэн 11 ажил

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн ажилтан нь 2015-2016 оны урьдчилан сэргийлэх ажлын тайланг холбогдох газруудаас авч нэгтгээгүй, зөвхөн аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн тайланг хүлээж авч архивласан нь аудитын явцад ажлын хэрэгжилтийг шалгахад хүндрэл учруулж байлаа.

2015-2016 онуудад Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиосон ажлын тайлангаа ирүүлээгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг Аймгийн ИТХ нь 2017 онд 29.5 сая төгрөгийн төсөвтэйгээр баталсан бөгөөд 21.4 сая төгрөгийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд, 8.1 сая төгрөгийг аймгийн ГХУСАЗСЗ-ийн ажилтныг цалинд тус тус зарцуулна, орон нутгийн хөгжлийн сангийн 62.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улиастай, Тосонцэнгэл сумдын гудамж талбайг камержуулна гэж төлөвлөжээ.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2017 оны төлөвлөлт өмнөх онуудаас сайжирсан боловч иргэний өмчийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлууд төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тайлан, мэдээ гаргах загвар 2017 оны 7 дугаар сард шинэчлэгдсэн, мэдээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын сурталчилгааны хэлбэр, иргэд аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулсан байдал,

иргэд байгууллагыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулсан байдал, холбогдох 8 газруудаас хэрэгжүүлсэн чиг үүргийн биелэлт, тайланд 9 төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгадаг болсон байна.

3-р улирлын тайланд Прокурорын байгууллагын хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хэрэгжүүлсэн чиг үүрэг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан санхүүжилтийг тусгаагүй байна.


2017 онд төлөвлөгдсөн ажлуудын хэрэгжилтийг 3-р улирлын байдлаар шалгахад 11 ажил нь хэрэгжээгүй, биелэлт нь 66.7 хувьтай байна.

Цаашид гэмт хэрэгтэй тэмцэх иргэдийн сайн дурын бүлэг, “Малчдын бүлэг” – үүдийг байгуулах, тэднийг чадавхжуулах, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, сургуулийн орчны хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, архи тамхи хэрэглэдэггүй хамт олныг шалгаруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэдийг шагнаж урамшуулах гэсэн төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлэхийн тулд хариуцсан байгууллагуудад үүрэг чиглэл өгч биелэлтийг тооцож ажиллах шаардлагатай байна.

1.1.3 Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоож байна.

Аймгийн Цагдаагийн газар нь хорих ялаас тэнсэн суллагдсан болон ялын хугацаа дуусч суллагдсан иргэдэд хяналт тогтоохдоо иргэн тус бүрд нь хяналтын хувийн хэрэг нээн, хувийн хэрэгт байвал зохих материалыг бүрдүүлэн ажилласан байна. Цагдаагийн байгууллага захиргааны хяналтыг хэрхэн тогтоож байгаад Прокурорын газраас тухай бүр хяналт тавьж ажиллажээ.

Захиргааны хяналт тогтоосон иргэдээс дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдол гараагүй бөгөөд 2016 онд хорих ялаас тэнсэн суллагдсан 1 иргэн захиргааны хяналтаас зайлсныг эрэн сурвалжилж албадан ирүүлсэн байна. Хорих ял эдлээд суллагдсан иргэдэд захиргааны хяналт тогтоож байх хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд: 4 иргэнийг бичиг баримттай болгож, 4 иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулан гэр оронтой болгох ажлыг зохион байгуулж, 1 иргэнийг ажилд жуулчлан, 5 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулан санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.



1.1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулахдаа хуулинд заасан хэлбэрийг сонгоогүй байна.

Аймгийн ГХУСАЗСЗ нь 2015 оны 1-4 сарын хугацаанд аймгийн хэмжээнд 28 олон нийтийн Цагдаагийн ажилтныг ажиллуулан сумдын орон нутгийн төсвөөс 21.5 сая төгрөгийн цалинг олгох асуудлыг шийдвэрлэж өгчээ. Аудитаар уг шийдвэрийн хэрэгжилтийг шалгахад 21 сумдын ГХУСАЗСЗ нь олон нийтийн цагдаагийн ажилтанд 11.8 сая төгрөгийн цалинг олгосон байна.

Төсөв хөрөнгөний дутагдалтай байдлаас шалтгаалан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “иргэдийг нийтийн эргүүлд гаргах”, 12.1.2-д “иргэдийг хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр томилох” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, 2015 оны 05 дугаар сараас хойш олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг ажиллуулаагүй байна.

Аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар нь иргэд, аж ахуй нэгж байгууллагуудыг дараахь хэлбэрээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж байна.

Үүнд:

- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхдээ мэргэжлийн байгууллагуудын ажилтнуудыг татан оролцуулах
- Баяр ёслолын үеэр төсвийн байгууллагуудын ажилтнуудыг хариуцлагатай жижүүрээр томилуулах
- Аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийх
- Сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах

1.1.5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалтын үр дүнтэй зохион байгуулж байгаа ч цаашид гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгахад чиглүүлэх шаардлагатай байна.

Аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар, Онцгой байдлын газар, АЗДТГ-ын Хууль зүйн хэлтсээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль тогтоомжийг иргэдэд сурталчлахдаа тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлгийг хэвлүүлэн иргэдэд



тараах, Цагдаагийн газрын иргэдийн хүлээлгийн танхимын телевизээр 9 төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх богино хэмжээний сурталчилгааг бэлтгэн үзүүлэх, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд мэдээлэл тавих, сургалт сурталчилгаа явуулах зэрэг аргуудыг ашиглаж байна.

№	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын тоо	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн сургалт, сурталчилгааны ажлын тоо	Хяналт шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо	Сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо
2015	1040	276	628	33219
2016	789	176	372	13719
2017	142	103	317	22661

Тайлант онуудад хийгдсэн сургалт, сурталчилгааны ажлын үр дүнг шалгахдаа дараах жилд нь гарсан гэмт хэргийн тоо хэмжээ, шалтгааныг харьцуулан дүгнэлээ.

- 2015 онд хийгдсэн сургалт сурталчилгааны ажлын үр дүнд мал хулгайлах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын тухай журмын эсрэг, хорих ял эдлээд суллагдсан иргэдээс үйлдэгдэх гэмт хэрэг 2016 онд буурсан байна. Гэтэл согтуугаар үйлдэгдсэн, насанд хүрээгүй иргэдээс үйлдэгдсэн, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргүүд өмнөх оноос өссөн нь сургалт сурталчилгааны ажлыг урамшууллын бодлогоор дэмжээгүй, сургалт сурталчилгаа нь гэмт хэрэг үйлдээд

байгаа насанд хүрээгүй иргэдийн байршил, шалтгааныг арилгахад чиглэгдээгүй байна.

- 2016 онд хийгдсэн сургалт сурталчилгааны ажлын үр дүнд мал хулгайлах, хорих ял эдлээд суллагдсан иргэдээс үйлдэгдэх, согтуугаар үйлдэгдэх, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг гэмт хэрэг нь 2017 онд буурсан байна. Гэтэл тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын тухай журмын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос өссөн нь иргэд бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодох, жолоочийн ур чадвар дутмаг байгаагаас шалтгаалсан нь жолооч нарт чиглэсэн сургалт болон жолооны сургалтын чанарт чиглэсэн хяналт шалгалтыг явуулаагүйгээс шалтгаалсан байна гэж үзлээ.

Бүлэг 1.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зарим арга хэлбэр нь үр дүн муутай байна.

1.2.1 Гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах гэсэн арга хэлбэр нь өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй байна.

Төсөв хөрөнгөний дутагдалтай байдлаас шалтгаалан иргэдийг нийтийн эргүүлд гаргах, хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр томилох зэрэг ажлуудыг зохион байгуулаагүй байна.

2015-2017 онд аймгийн хэмжээнд иргэдийг нийтийн эргүүлд гаргах, хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр томилох зэрэг ажлуудыг зохион байгуулаагүйгээс гэмт хэргийн илрүүлэлт жил бүр буурч байгааг аймгийн ГХУСАЗСЗ анхаарч ажиллах нь зүйтэй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах ажлыг жил бүр төлөвлөдөг боловч батлагдсан санхүүжилтийг аймгийн ГХУСАЗСЗ зориулалт бус зарцуулснаас шалтгаалан хэрэгжээгүй байна.

Гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах ажил нь орон нутагт хэрэгжих боломж муутай байна. Учир нь орон нутагт иргэд бие биенээ таньдаг, төрөл садан, аль болохоор хэргийн гэрч болохоос татгалздаг, мэдээлэл авах төлбөрийн хэмжээ бага байдаг зэрэгтэй холбоотой байна гэж үзэх үндэслэлтэй. Тайлант хугацаанд аймгийн Цагдаагийн газраас 1.0 сая төгрөгийн төлбөртэйгээр гэмт хэргийн мэдээлэл авахаар зар явуулсан боловч иргэд мэдээлэл ирүүлээгүй байна.

Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох ажил үр дүнтэй хэрэгжиж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах хэлбэр нь аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар ахлуулсан орон тооны бус зохицуулах зөвлөл юм.

Аймгийн ГХУСАЗСЗ нь 2015 онд 19, 2016 онд 21, 2017 онд 23 хүний бүрэлдэхүүнтэйгээр, сумдын салбар зөвлөл нь 7-15 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

1.2.2 Аймгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтэс, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын уялдаа холбоо муу байгаагаас зарим чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Засаг дарга нь Хууль зүйн сайдтай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2015 онд 13 ажил, 2016 онд 10 ажил, 2017 онд 18 ажил хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд дараах ажлуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн аймгийн нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулаагүй байна.

- 2015-2016 онуудад гэмт хэрэг ихээр үйлдэгддэг газруудыг телекамерын хяналтанд авах ажлыг төсөв хөрөнгөний хүрэлцээгүй байдлаас шалтгаалан тусгуулаагүй, харин 2017 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулсан
- 2015-2016 оны төлөвлөгөөнд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр хийж байгаа ажлыг сурталчлах, 2017 оны төлөвлөгөөнд мөнгө угаах, хүний наймаа, хар тамхи, цахим гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлыг тусгуулаагүй байна.

Аймгийн Засаг дарга нь нөөц хөрөнгөнөөсөө 2015-2017 онд аймгийн Цагдаагийн газарт 24.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгон хамтран ажиллажээ. Мөн аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэст гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2016 онд 1.3 сая, 2017 онд 1.4 сая төгрөгийн санхүүжилтүүдийг олгосон байна.

Харин аймгийн ГХУСАЗСЗ нь 2015-2017 онд аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэст төлөвлөсөн ажлуудыг нь хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг олгоогүй байна.

Иймээс аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс нь сайдтай байгуулсан гэрээний биелэлтийг гаргахдаа хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллаж, тухайн байгууллагуудын хийсэн ажлын тайланг аван нэгтгэх үүргийг хэрэгжүүлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагыг дэмжин туслах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, аймгийн ГХУСАЗСЗ-ийн ажлын уялдаа холбоо муу, харилцан мэдээлэл солилцдоггүй, нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар хамтран ажилладаггүй байдал ажиглагдлаа.

Аймгийн ГХУСАЗСЗ салбар зөвлөл нь аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, Прокурорын газар, Онцгой байдлын хэлтэс зэрэг газруудаас ажлын тайланг гаргуулж аваагүй, гэмт хэргийн байдал, түүний шалтгаан нөхцлийн талаархи статистик мэдээг солилцох чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна гэж үзлээ.

Сумдын ГХУСАЗСЗ, сумдын ЗДТГ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхдээ аль болох хөрөнгө мөнгө бага шаардагдах ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлдэг, аймгийн ГХУСАЗСЗ-ийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд өөрсдийн нөөц, боломжийн хирээр оролцдог байна. Энэ нь төсөв мөнгөний хүрэлцээгүй байдлаас шалтгаалан сумдын салбар зөвлөлд

аймгийн ГХУСАЗСЗ нь төсөв хөрөнгө хуваарилдаггүй, сумдад техник тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгсэл хүрэлцээ муутай, санхүүгийн нөөц дутагдалтай байдгаас шалтгаалдаг байна гэж үзлээ.

Цаашид аймгийн ГХУСАЗСЗ нь гэмт хэрэг ихээр гардаг сумдын ЗДТГ-т гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Засаг даргад гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан хуваарилж зарцуулна” гэж заасны дагуу төсөв хөрөнгө хуваарилснаар сумдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

1.2.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүд нь хуульд заасан зарим чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 23-ны 85 тоот тогтоолоор аймгийн ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн баталжээ. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн хуульд заасан чиг үүргийн хэрэгжилтийг шалгахад дараахь ажлуудыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

1. Аймгийн Засаг дарга, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Эрүүл мэндийн газар, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар, Боловсрол соёлын газар, аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс зэрэг газруудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын тайланг гаргуулж аваагүй
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулаагүй
3. Гэмт хэргийн байдал, түүний шалтгаан нөхцлийн талаархи статистик мэдээг солилцохгүй байгаагаас 2015-2017 оны нэгдсэн төлөвлөгөөнд иргэний өмчийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийг тусгаагүй байна
4. 2015-2016 онуудад хуралдсан аймгийн ГХУСАЗСЗ-ийн хуралдааны тэмдэглэл байхгүй, сумдын салбар зөвлөлийн ажилд хяналт тавьж ажиллаагүй
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын тодорхой хэсгийг зориулалт бус зарцуулсан

Сумдын салбар зөвлөлүүд нь 2015-2016 онуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын тайлангаа аймгийн салбар зөвлөлд ирүүлээгүй байна.

Бүлэг 1.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулагдсан төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдаж байна.

1.3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийн хөрөнгө 2016-2017 онд хуульд заасан хэмжээнд төлөвлөгдөөгүй байна.

Тайлант хугацаанд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр ногдуулан орон нутгийн төсөвт тушаасан хүү, торгуулийн орлогыг судлан үзэхэд дараахь байдалтай байна.

он	Зөрчлийн тоо	Тайлант онд ногдуулсан хүү, торгууль /сая төгрөгөөр/	Тайлант онд төсөвт төвлөрүүлсэн орлого /сая төгрөгөөр/	Хуульд заасан 40%	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсөв
2014	8562	56.3	58.9		
2015	9668	107.5	156.7	23.6	27.5
2016	5621	295.5	171.9	62.7	27.5
2017	5720	331.3	121.5	68.8	29.5

2016-2017 онуудад аймгийн хэмжээний гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын төсөв нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 19 дүгээр зүйлийн 19.1-д “Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу төлөвлөгдөөгүй байна.

1.3.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуультай, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгосон нэмэлт санхүүжилт нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан журамтай нийцээгүй, аймгийн Засаг дарга нь төлөвлөлгүйгээр 7.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2015-2017 онуудад аймгийн Засаг дарга нь нөөц хөрөнгөнөөсөө Хууль зүйн сайдтай байгуулсан гэрээ, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 21.2 сая төгрөгийн, 2016 онд аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй 7.8 сая төгрөгийн санхүүжилтийг нэмж олгосон байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 2017 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан гудамж талбайг телекамержуулах арга хэмжээний санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд 2015-2017 онд аймгийн Цагдаагийн газарт Эрдэнэхайрхан суманд зохион байгуулагдсан Нүүдэлчдийн баярын үед хэв журам сахиулахад 11.0 сая төгрөгийн, 2015-2017 оны ардын хувьсгалын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх үеийн хэв журам сахиулахад 22.2 сая төгрөгийн санхүүжилтүүдийг тус тус олгожээ. Аймгийн Цагдаагийн газарт олгосон санхүүжилтүүд нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан боловч Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг зөрчсөн байна.

Тайлант хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олгосон төсвийн болон нэмэлт санхүүжилтийг судлан үзэхэд дараах байдалтай байна.

/ сая төгрөгөөр/

Орлого				
он	Батлагдсан төсвөөс олгосон санхүүжилт	Аймгийн Засаг даргын нөөц сангаас нэмж олгосон	Аймгийн ОНХС-аас санхүүгийн дэмжлэг	Дүн
2015	27.5	11.0	8.4	46.9
2016	27.5	13.4	7.3	48.2
2017	25.2	4.6	17.5	47.3

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн сангаас олгосон санхүүгийн дэмжлэгийг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл нь 2015-2017 оны тайландаа тусгаагүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс олгосон нийт санхүүжилтийн хэмжээ нь 2016 онд хуулинд заагдсан хэмжээндээ

хүрээгүй, харин 2017 онд ОНХС-аас хийгдсэн 44.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг тооцвол хуулинд заагдсан хэмжээнээсээ 22.5 сая төгрөгөөр, 2015 онд хуулинд заагдсан хэмжээнээсээ 3.9 сая төгрөгөөр тус тус илүү байна.

1.3.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хуваарилагдсан төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулан гэмт хэргээс сэргийлэх тухай хуулийг зөрчжээ.

2015-2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгожээ. Зарцуулалтыг шалгахад 2015 онд сургалт сурталчилгаанд 14.2 сая төгрөгийг, иргэний зөвлөлийн урамшуулалд 0.9 сая төгрөгийг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтны цалинд 1.7 сая төгрөгийг, зориулалт бусаар 10.7 сая төгрөгийг, 2016 онд сургалт сурталчилгаанд 4.5 сая төгрөгийг, гадаад томилолтонд 3.8 сая төгрөгийг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтны цалинд 8.5 сая төгрөгийг, зориулалт бусаар 10.7 сая төгрөгийг, 2017 оны эхний 9 сарын байдлаар сургалт сурталчилгаанд 8.7 сая төгрөгийг, зориулалтын хувцас худалдан авахад 1.0 сая төгрөгийг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтны цалинд 6.3 сая төгрөгийг, зориулалт бусаар 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Зарцуулалтын баримтын бүрдлийг шалгахад 2016 онд зарцуулсан 0.9 сая төгрөгийн зардал нь анхан шатны баримтаар бүрэн нотлогдохгүй байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2015 онд 11.0 сая төгрөгийн, 2016 онд 13.4 сая төгрөгийн, 2017 онд 4.6 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Зарцуулалтыг шалгахад 2015 онд сургалт сурталчилгаанд 2.0 сая төгрөгийг, иргэний зөвлөлийн урамшуулалд 3.5 сая төгрөгийг, Их-Уул сумын гүүрний засварын ажилд хяналт тавихад 4.0 сая төгрөгийг, зориулалт бусаар 1.1 сая төгрөгийг, 0.4 сая төгрөгийг дутагдуулсан, 2016 онд сургалт сурталчилгаанд 3.3 сая төгрөгийг, гадаад томилолтонд 2.0 сая төгрөгийг, Дөрвөлжин, Завханмандал сумын нутаг дэвсгэрт гар аргаар алт олборлолт хийдэг иргэдэд хяналт тавиж, тараахад 2.5 сая төгрөгийг, иргэний зөвлөлийн урамшуулалд 4.3 сая төгрөгийг, зориулалт бусаар 1.3 сая төгрөгийг, 2017 оны эхний 9 сарын байдлаар сургалт сурталчилгаанд 1.4 сая төгрөгийг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд 0.7 сая төгрөгийг, цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэхэд 2.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аймгийн ОНХС-аас ардын хувьсгалын баяр наадмын үеэр хэв журам сахиулахад зориулан аймгийн Цагдаагийн газарт 2015 онд 8.4 сая төгрөгийн, 2016 онд 7.3 сая төгрөгийн, 2017 онд 6.5 сая төгрөгийн, Эрдэнэхайрхан суманд зохион байгуулагдсан нүүдэлчдийн баярын үед хэв журам сахиулахад зориулан 2017 онд 11.0 сая төгрөгийн санхүүжилтүүд олгосныг зориулалтын дагуу зарцуулжээ.

Цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтсээс олгохдоо аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас олгосон санхүүжилтийг суутган тооцох нь зүйтэй байна.

1.3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хуваарилагдсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа байдалд хяналт тавих шаардлагатай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хуваарилагдсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд тусгагдсан аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт тавиагүй байна.

Аудитаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс дутагдуулсан 0.4 сая төгрөгийг төлбөр болгож, аймгийн ГХУСАЗСЗ-ын 2015-2016 онд зориулалт бус болон анхан шатны баримтгүйгээр зарцуулсан 24.7 сая төгрөгийн, 2017 онд зориулалт бус зарцуулсан 1.8 сая төгрөгийн зөрчлүүдийг илрүүлэн, аймгийн ГХУСАЗСЗ-д зөвлөмж хүргүүлээ.

ДҮГНЭЛТ: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийн хөрөнгийг хуулинд заасан хэмжээгээр төлөвлөж батлаагүйгээс аймгийн ГХУСАЗСЗ зарим чиг үүргээ хэрэгжүүлж чадаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Ихэнх гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох чиг үүрэг хэрэгжиж байгаа ч иргэний өмч хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг орхигдсон байна.
2. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцлийг арилгах нийгэм эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг 2015-2016 онд бодитой төлөвлөөгүй, санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулдгаас шалтгаалан хэрэгжилт нь хангалтгүй байна.
3. Аймгийн Цагдаагийн газраас давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоож байна.
4. Төсөв хөрөнгөний дутагдалтай байдлаас шалтгаалан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12.1.1-д иргэдийг нийтийн эргүүлд гаргах, 12.1.2-д иргэдийг хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр томилох гэж заасныг хэрэгжүүлээгүй, 2015 оны 05 дугаар сараас хойш олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг ажиллуулаагүйгээс гэмт хэргийн илрүүлэлт буурчээ.
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалтыг үр дүнтэй зохион байгуулж байгаа ч цаашид насанд хүрээгүй иргэдээс үйлдэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын тухай журмын эсрэг зэрэг гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгахад чиглүүлэх шаардлагатай байна.
6. “Гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах” гэсэн арга хэлбэр нь өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй байна.
7. Аудитаар аймгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтэс, аймгийн ГХУСАЗСЗ-ийн ажлын уялдаа холбоо муу, харилцан мэдээлэл солилцдоггүй, нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар хамтран ажилладаггүй байдал ажиглагдлаа.
8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүд нь хуульд заасан зарим чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна .
9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийн хөрөнгө 2016-2017 онд хуульд заасан хэмжээнд төлөвлөгдөөгүй байна.
10. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуультай, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгосон нэмэлт санхүүжилт нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан журамтай нийцээгүй, аймгийн Засаг дарга нь төлөвлөлөгүйгээр 7.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

11. Төсөв хөрөнгөний дутагдалтай байдлаас шалтгаалан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “иргэдийг нийтийн эргүүлд гаргах”, 12.1.2-д “иргэдийг хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр томилох” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, 2015 оны 05 дугаар сараас хойш олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг ажиллуулаагүй байна.
12. Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс нь сайдтай байгуулсан гэрээний биелэлтийг гаргахдаа хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллаж, тухайн байгууллагуудын хийсэн ажлын тайланг аван нэгтгэх үүргийг хэрэгжүүлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагыг дэмжин туслах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
13. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хуваарилагдсан төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчиж байна.
14. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хуваарилагдсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд тусгагдсан аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт тавиагүй байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга Ц.Балхярваа танаа

1. Гэмт хэргийн байдал, түүний шалтгаан нөхцлийн талаархи статистик мэдээг харилцан солилцох ажлыг аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газартай хамтран хэрэгжүүлэн, аймагт зонхилон үйлдэгддэг гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах нийгэм эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг бодитой төлөвлөх, 2017 оны нэгдсэн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах
2. 2018 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг хуулинд заасны дагуу төлөвлөн, зориулалтын дагуу зарцуулах, 2017 оны зориулалт бус зарцуулалтын зөрчлийг залруулах
3. Олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг ажиллуулах, иргэдийг хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр томилох, нийтийн эргүүлд гаргах зэрэг ажлуудыг 2018 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгахад чиглүүлэх
4. Аймгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтэстэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлын уялдаа холбоогоо сайжруулан, нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах, холбогдох байгууллагуудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын тайланг гаргуулж нэгтгэх
5. Гэмт хэрэг ихээр гардаг сумдын ЗДТГ-т гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.2-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Засаг даргад гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан хуваарилж зарцуулна” гэж заасны дагуу төсөв хөрөнгө хуваарилах, сумдын салбар зөвлөлүүдийн ажлын тайланг нэгтгэн, үнэлж дүгнэх
6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хуваарилагдсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаад тавих дотоодын хяналтыг сайжруулах

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.БАТСАЙХАН ТАНАА

1. 2018 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг хуулинд заасны дагуу төвлөрүүлэн олгох
2. Аймгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтэст гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагыг дэмжин туслах чиг үүргээ хэрэгжүүлэх, нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар аймгийн ГХУСАЗСЗ-тай хамтран ажиллах үүргийг хүргүүлэн биелэлтийг тооцож ажиллах
3. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг аймгийн ИТХ-ын нэмэлт дансанд байршуулах, 2017 оны санхүүжилтийг тооцохдоо аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас олгосон санхүүжилтийг суутгах, цаашид аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас нэмэлт санхүүжилт олгохыг зогсоох үүргийг хүргүүлэн хэрэгжүүлэх

Гүйцэтгэлийн аудитаар тогтоогдсон төлбөр, зөрчлийг заасан хугацаанд барагдуулж, өгөгдсөн дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн биелэлтийг 2017 оны 12-р сарын 20-ний дотор албан тоотоор ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР